

2020 ОНЫ 1-Р УЛИРАЛД ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА,
АЛБАН ТУШААЛТАНД ХАНДАЖ ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН
ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТУХАЙ

2020.03.31

Аймгийн хэмжээнд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч барагдуулах, шийдвэрлэлтэнд хяналт тавих, мэдээлэх журмын дагуу Засаг даргын Тамгын газрын 6 хэлтэс, 15 сум, 22 газар агентлагууд иргэдээс өргөдөл гомдол санал хүсэлтийг утсаар, цахимаар, бичгээр, авч шийдвэрлэн явцын мэдээллийг 7 хоног бүр төрийн байгууллагын Эйбль цахим програмд байршуулан олон нийтэд мэдээллэн ажиллаж байна.

2020 оны 1-р улиралд Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар болон 15 сум, 22 агентлагт хандаж иргэдээс биеэр, цахимаар, утсаар, бичгээр, нийт 3573 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс 3409 өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж 95,4%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж 133 өргөдөл, гомдол, санал хүсэлт шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна. Хугацаа хоцроож шийдвэрлэгдсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт байхгүй байна

Засгийн газрын Иргэд олон нийтээр харилцах төвийн “1111” утсанд 2020 оны 1-р улиралд Дундговь аймагтай холбоотой гомдол, санал хүсэлтийн дуудлага мэдээлэл 1 ирж шийдвэрлэгдсэн байна.

Аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газарт хандан 29 өргөдөл бичгээр ирсэн бөгөөд 23 нь иргэдээс, 4 нь ажилтнаас, 2 нь хамт олноос ирсэн байна. Өргөдөл 22, гомдол 1, хүсэлт 6 байгаагаас 24 өргөдөл хугацаандаа шийдвэрлэгдэж 2 өргөдөл, 1 гомдол, 2 хүсэлт шийдвэрлэлтийн шатандаа байна.

Засаг даргын Тамгын газрын нээлттэй утас 7059106 дугаарт нийт 9 дуудлага хүлээн авснаас 7 гомдол, 1 талархал, 1 өргөдөл байна. 6 өргөдөл хугацаандаа шийдвэрлэгдэж 3 гомдол шийдвэрлэлтийн шатандаа хүлээгдэж байна.

Аймгийн төвийн Сайнцагаан суманд хог хаягдал, гэрэлтүүлэг, сум орон нутгийн хөгжил, тохижилттой холбоотой 23 иргэнээс өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлсний дагуу сумын Засаг захирамж гарган сар бүрийн сүүлийн 7 хоногт иргэд, ААНэгж, төрийн байгууллагуудыг их цэвэрлэгээнд гаргаж ойр орчмын хогийг цэвэрлүүлж байна. Мөн Нарлаг багийн “Шар байр”, Боржигон сүрээгийн байрны урд талын эзэнгүй хогийг Хот тохижуулах газартай хамтран 28 иргэнээр 5 машин буюу 40 тонн хог цэвэрлэж ачууллаа. 9-н багт гаргасан хуваарийн дагуу хог ачилтын машиныг ажиллуулж байна.

Бүх сум, хэлтэс, агентлагийн иргэдтэй шууд холбогдох нээлттэй утасны дугаар болон цахим хаягийн судалгааг нэгтгэн, 7059106 утсанд хандсан иргэдэд байгууллага, албан тушаалтнуудтай шуурхай холбогдох боломжийг олгон шаардлагатай мэдээллээр тухай бүрт нь ханган ажиллаж байна. Сум, агентлагийн нээлттэй утасуудын байнгын ажиллагааг ханган иргэдийн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэн ажиллах чиглэлийг өгч удирдлага арга зүйгээр ханган ажиллаж байна.

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС